

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН  
2024 ОНЫ 08 ДУГААР САРЫН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2024 оны 09 дүгээр сарын 04

Улаанбаатар хот

Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн тус байгууллагад холбогдох зүйл, заалтуудын 2024 оны 08 дугаар сарын хэрэгжилтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хяналт-шинжилгээ хийж, үр дүнг дараах байдлаар үнэлэв.

Хяналт-шинжилгээ, үнэлгээнд Засгийн газрын хуралдааны тэмдэглэлд тусгагдсан 1 арга хэмжээний 1 зүйл, заалтыг үйл ажиллагаандаа хамруулснаас нийт үнэлгээгээр 90 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдлээ. (Хүснэгт 1)

Хүснэгт 1

Шийдвэрийн төрөл			
Бүгд		Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	
Хяналтад авсан хууль, тогтоол шийдвэрийн тоо		1	1
Заалтын тоо		1	1
ҮНЭЛ ГЭЭ	Хэрэгжих шатанд (90%)	1	1
	Хугацаа болоогүй	-	-
Үнэлгээ /хувь/		90	

Шийдвэрийн төрлөөр авч үзвэл Засгийн газрын хуралдааны тэмдэглэлээс “хэрэгжих шатандаа” буюу 90 хувь үнэлэгдсэн 1 арга хэмжээ байна. Үүнд:

**Арга хэмжээ-1:** 1.2.5.Иргэдийн зорчих нөхцөлийг хөнгөвчлөх талаар БНСУ-ын холбогдох байгууллагатай хэлэлцээ хийх үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулж, энэ хүрээнд дараах асуудлыг хэлэлцэхийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатарт:

-Монгол Улсын Засгийн газар болон БНСУ-ын Засгийн газар хооронд байгуулсан Нийгмийн хамгааллын тухай хэлэлцээрт холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулах замаар харилцан нийгмийн даатгалаас чөлөөлөх хугацааг нэмэгдүүлэх, төлөгдсөн нийгмийн даатгалын буцаан олголтод хамаарах визийн ангилал хүрээг нэмэгдүүлэх;

-БНСУ-д эмчилгээ хийлгэж буй иргэдийг дэмжих зорилгоор тус улсын эмнэлгүүдийн төлбөрийн хөнгөлөлтийг эдлүүлэх болон эрүүл мэндийн даатгалд хамрагдах;

-Хөдөлмөрийн гэрээгээр БНСУ-д ажиллаж буй монгол иргэдийн эцэг, эх, үр хүүхэд, гэр бүлийн зүгээс тус улсад зорчих виз хүсэхэд тодорхой хөнгөлөлт эдлүүлэх гэжээ.

**Хэрэгжилт:** Засгийн газрын 2023 оны “Монгол Улсын иргэдийн Бүгд Найрамдах Солонгос Улсад зорчих нөхцөлийг хөнгөвчлөх чиглэлээр авах арга хэмжээний тухай” 166 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах арга хэмжээний хүрээнд Гадаадын иргэн, харьяатын газрын дарга Бүгд Найрамдах Солонгос Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд Чой Жин Воныг 07 дугаар сарын 08-ны өдөр хүлээн авч уулзав. Уулзалтаар:

- Тогтвортой ажлын байртай, бизнесийн үйл ажиллагаа эрхэлдэг иргэдэд олон удаагийн виз олгох нөхцөлийг хөнгөвчлөх;
- Визийн хүсэлт шийдвэрлэх хугацааг богиносгох асуудалд анхаарал хандуулах;
- Виз мэдүүлгийн үйлчилгээг цахимжуулах талаар судалж үзэх зэрэг тодорхой саналуудыг дэвшүүллээ. (Хэрэгжилт 90 хувь)

Дүгнэлт, зөвлөмж

Гадаадын иргэн, харьяатын газрын 2024 оны 08 дугаар сарын Монгол Улсын хууль тогтоомж, тогтоол, шийдвэрт тусгагдсан 1 зорилт, арга хэмжээний хэрэгжилт “хэрэгжих шатанд” 90 хувьтай үнэлэгдлээ.

Цаашид дээрх арга хэмжээний үр дүнг бууруулахгүйгээр чанаржуулж, уулзалтаас гарсан саналын биелэлтийг эргэн тайлагнаж хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллахыг зөвлөж байна.

--oo0oo--